

## ӨВӨР МОНГОЛЫН ШИЛИЙН ГОЛ АЙМГААР АЯЛАХУЙ

Ч.Батцэцэг\*

У.Загдцэсэм\*\*

2011 оны 8 дугаар сарын 2-7-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн хотод “Зүүн Хойд Азийн бүс нутгийн олон талт соёлыг нэгтгэх эв зохистой хандлагын талаархи олон улсын эрдэмтдийн судалгаа” сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар хурал боллоо. Уг хурлыг Өвөр Монголын их сургуулийн Япон судлалын төв, Бээжингийн их сургуулийн Япон судлалын төв, Өвөр Монголын олон улсын соёлын солилцооны төв, Хятад дахь Японы гүн ухааны судалгааны нийгэмлэг хамтран зохион байгуулж, Япон сан, Японд суугаа БНХАУ-ын ЭСЯ, ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн засаг захиргаа ивээн тэтгэсэн юм. Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хуралд гадаад дотоодын нийт 150-иад хүн оролцсон бөгөөд нэгэнт япон судлалын төвүүд зохион байгуулж байгаа болохоор хурлын зочид, илтгэгч нар гол төлөв япон судлалын чиглэлээр ажилладаг эрдэмтэн багш нар байлаа. Хуралдаан 8 дугаар сарын 3-4-нд 4 салбар чиглэлээр хуралдсан. Үүнд: 1. ЗХА-ийн соёл ба сэтгэлгээ. 2. Япон хэлний боловсролыг олон талт болгох нь. 3. ЗХА-ийн бүс нутгийн байгаль экологийн байдал ба орчин үеийн нийгмийг бүрэлдүүлэх нь. 4. ЗХА дахь Япон судлал зэрэг болно.

Уг хуралд Монгол Улсаа төлөөлөн ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Ч.Батцэцэг, эрдэм шинжилгээний залуу ажилтан магистр У.Загдцэсэм бид хоёр оролцохоор Хөх хотод нисч ирэв. Биднийг Өвөр Монголын олон улсын соёлын солилцооны төвийнхөн угтан авч, шинэ дүүргийн буудалд оруулсан юм. Маргааш өглөө нь эртлэн босч Хөх хотоос Шилийн гол аймгийн зүг хөдөллөө. Замдаа Улаан цав аймгийн Дөрвөн ван хошуу, Авга хошууны Бэлэгтэй хот, Сайхан талын нутгаар бараг долоо найман цаг явсны эцэст Шилийн хотод ирэв. Хөтөлбөрийн дагуу 8 дугаар сарын 2-ны өглөө бүртгэлийн ажил, үдийн хойно Шилийн хотын орон нутгийн музей үзүүлсэн юм. 3-ны өглөө нээлтийн хуралдаан болов. Бид 4-нд “Монгол Улс, ӨМӨЗО-ы соёлын харилцааны асуудал”, “Монгол-Японы соёлын харилцааны тойм” сэдвээр тус тус хятад, япон хэлээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. 8 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд хээрийн шинжилгээ-судалгааны ажил Шилийн гол аймгийн Баруун Үзэмчин хошуу, Хишигтэн хошуу, Эрээн хотоор үргэлжилсэн юм.

\* Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

\*\* У.Загдцэсэм - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

ӨМӨЗО-ы Шилийн гол аймаг нь нүүрсний ил уурхайн баялаг орд газруудтай, түүнийгээ түшиглэн шинэ тутам хөгжиж, нутгийн ард иргэд нь уурхайнхаа хувьцааг эзэмшснээр амьжиргааны түвшин асар их дээшилж байгаа “Тал нутгийн диваажин Шилийн гол” хэмээн нэрлэгддэг нутаг ажээ. Шилийн гол аймагт Шилийн хот, Эрээн хот, Зүүн Үзэмчин хошуу, Баруун Үзэмчин хошуу, Авага хошуу, Сөнидийн зүүн хошуу, Сөнидийн баруун хошуу, Тайгус хошуу, Жэнлан хошуу, Долон сум, Улагай гэсэн засаг захиргааны нэгжтэй. Шилийн хот нь аймгийнхаа засаг захиргаа, улс төр, эдийн засаг, соёлын төв бөгөөд харин Эрээн хот бол БНХАУ-ыг Монгол Улс, Зүүн Европын орнуудтай холбосон чухал боомт газар юм.

Хурлын эхний өдөр төлөөлөгчдөд Шилийн хотын орон нутгийн музей үзүүлсэн гэж дээр дурьдсан. Хэрэв та тухайн улс үндэстнийг сайтар таньж мэдэж авъя гэвэл эхлээд орон нутгийн музейг нь заавал үзэх хэрэгтэй гэдэг. ӨМӨЗО-ны Хөх хотод музейгээ шинэчилж музейн асар том, орчин үеийн хийц загвартай цогцолбор барилга барьжээ. Шилийн хотын музей мөн адил монгол гэр хэлбэртэй, аймгийн музей гэхэд манай улсад л лав байхгүй томоохон музей байсан юм. Энэ музейн үзмэр голдуу монголчуудын түүх, ахуй соёл, зан үйл, уламжлалыг харуулсан бүтээл байв. Музейн ганц үнэ цэнэтэй зүйл нь Чингис хаан өөрөө хэрэглэж байсан байж болох хаш тагш хэмээн тайлбарлагч үзүүлэв. Тагшны амсар дээр монгол бичгээр Тэмүүжин хэмээн бичсэн байх бөгөөд Юань улсын үеийн дээд нийслэл Шаньдугаас олдсон олдвор гэж тайлбарлаж байв. Хурлын хоёр дахь өдөр Шилийн хотын хойд зүгийн “Эрдэнэ толгой”-н Овоо уулын бэлд 1734 онд байгуулагдсан Бэйсийн хийдээр тойруулсан юм. Бэйсийн хийд нь Өвөр Монголын бурхны шашны томоохон 4 хийдийн нэг агаад одоо хийдэд лам хувраг ном хурдаг, сүсэг бишрэлтэй олны очдог, жуулчны үздэг их хөлийн газар аж. Хийдийн дээд хэсэгт Эрдэнийн 13 том овоотой, шатаар өгсөж тойрдог, цэцэрлэгээр хүрээлэгдсэн уултай, устай, хийдийн ойр орчимд бэлэг дурсгалын худалдааны газруудтай сайхан газар байв. Шилийн хотод орчин үеийн шинэ шинэ дүүрэг, хороолол, орон сууц болоод албан байгууллагын асар, зочид буудал, засмал зам, төмөр зам, урлаг соёл, спортын өнгө үзэмжтэй, орчин үеийн хийцтэй цогцолбор барилга байгууламж маш ихээр баригдаж байна. Хотын дундуур Шилийн нууртай, усан оргилуур, томоохон баримал хөшөө сүндэрлэн босчээ. Дашрамд, хот дотор сүндэрлэн босох хөшөө баримлын тухайд, Өвөр Монголын нутгаар явахад монгол үндэстний эд өлгийн зүйл, ахуйн хэрэглээ, хээ угалз, гээд л ер нь монголчуудын дээдэлдэг бүхнээр баримал хөшөө хийсэн байх нь сонин содон харагдаж нэгийг бодогдуулж явлаа. Тухайлбал: морь унаж уургаа барьсан адуучин эр, таван хошуу мал, үхэр тэргээс гадна 20 давхар байшин шиг өндөр алтадсан тулга, домбо, мөнгөн аяга, ардын

хөгжмийн зэмсэг морин хуур, эмээл, юүдэн малгайн том том баримал байх, зар сурталчилгааны самбараа алхан хээ, ланз хээгээр суурилуулан тавьсан байх жишээтэй. Манай улсын нийслэл Улаанбаатар хотод эрэмдэг зэрэмдэг ур хийц муутай хүний дүрс хөшөө байдаг нь уран сэтгэмж, хөрөнгө мөнгө, хөдөлмөрлөх хүчний дутагдал, өөрийн үйлдвэр байхгүйгээс болдог биз. Шилийн хотод олон улсын чанартай хурал, уралдаан тэмцээн гээд янз бүрийн арга хэмжээ ар араасаа үргэлжилж, зочдоо хүлээн авсаар байлаа. Зохион байгуулж буй арга хэмжээг тухай бүрд нь хэвлэл мэдээллээр цацаж байгаа нь шинэ тутам хөгжиж буй аймаг хотод гадаадын болон дотоодын жуулчид, хөрөнгө оруулагчдыг ихээр татах нэг хэлбэр юм гэж хөтөч маань ярьж билээ.

Хурлын дараагийн өдрүүдэд хээрийн судалгааны ажил үргэлжилж, Шилийн гол аймгийн жуулчны баазуудаар хэдэн зуун км газрыг автобусаар туулсан юм. Хишигтэн хошууны Асгат хэмээх дэлхийн геологийн паркаар аялуулж уулан дээрхи асар том хад асга хавцлыг үзүүлэхийн тулд уул тойруулан зассан замаар автобусаар хүргэж, өөрсдөө дээшээ шатаар өгсөн хүрч байгалийн сайхан тогтолцоо, ой мод хад асгадын зохиролыг харж баясаж явав. Энэ паркийг ЮНЕСКО-д соёлын биет өвөөр бүртгүүлсэн ажээ. Шилийн гол аймгийн онгон байгалийг харахаас гадна 10 жилийн өмнөөс БНХАУ-ын Баруун бүсийг хөгжүүлэх төсөлд Өвөр Монголыг бүх Хятадын экологийн ногоон бүс болгоно гэсэн төлөвлөгөө хэрэгжиж чухам энд жинхэнэ биелэлээ олж байгаа, бүхэл бүтэн ой мод тарьсан байдал, ногоон байгууламжийг хараад хятадын ард түмний уйгагүй ажилч хичээнгүй, хөдөлмөрч чанарыг дотроо гайхаж явснаа нуух юун. Бидэнтэй хамт хуралд оролцсон ОХУ, Япон, Солонгосын төлөөлөгчдөөс бусад нь Хятадын Бээжин, Шанхай, Далянь, Сямьнь болон бусад олон хотоос ирсэн эрдэмтэн багш нар байв. Тэд цэлийсэн удам нов ногоон тал хөндийгөөр аялж явахдаа хэдэн зуун км үргэлжлэх сайхан тал нутгийг бахдан гайхаж, дуу алдаж, бэлчиж яваа адуу, үхэр, хонин сүргийн зургийг авах гэж байсхийгээд автобус зогсоож байсан нь зам хорооход нөлөөлж, буудаллах газартаа бүр үдэш ирж байсан билээ. Баян-Овоо жуулчны баазад хооллож, Баруун Үзэмчин хошууны буудалд хоноглов. Шилийн гол аймаг “Үзэмчний тарган хонь”-иороо алдартай, хонин сүрэг дотор нэг ч ямаа байхгүй харин ямаан сүрэг нь Ордост бий. Ордос бол дэлхийд ноолуураараа алдартай гээд төрөлжүүлэн малаа өсгөдөг байна. Гэтэл манай хөдөөгүүр явахад хонь ямаан сүрэг холилдон бэлчээр нутгаа талхлах болсон. Биднийг “Чингисийн хүрээ хот” гэдэг жуулчны томоохон газар авчирч морь, тэмээ унуулж, монгол гэрээр оруулж, зураг хөргөө авахуулав. Үдэд “Чингисийн буудаллаж байсан уул”-нд хээрийн хоол идүүлэхээр

уулын хормойд буулгав. Төлөөлөгчид тал тал тийшээ явж, уулын оройд гарах нь гарч, хоёр цагийн дараа эргэн ирж, унаандаа суухад уугаар дүүрэн мөөг, мангир, хөмүүл түүсэн хүн олон байлаа. Уг нь энэ уулыг Сэргэлэн Хараат уул хэмээн нэрлэдэг, жуулчдыг л татах гэж Чингисийн нэрийг оруулж байгаа гэж өвөр монголын нөхдүүд хэлж билээ. Бид наргиан болгож эзэн Чингис хаан маань мөн ч олон хүнийг хооллох юм даа гэцгээв. Тэндээсээ Шилийн хот руу явж аймгийн наадам үзэх төлөвлөгөөтэй байсан боловч явсаар байгаад оройтож бөх дууссан хойно наадмын талбайд ирсэн юм. Өвөр Монголын наадам 8 дугаар сарын эхээр болдог байна. Шилийн гол аймаг нь монгол үндэстний ардын өв уламжлал, зан заншил, ахуй соёлоо асар ихээр хадгалж үлдсэн нутаг. Өвөр Монголын алдартай ардын дуу бүжгийн “Улаан мөчир” чуулга 1958 онд Шилийн гол аймагт үүсчээ.

Дараагийн өдөр хурлын хөтөлбөр ёсоор төлөөлөгчид Эрээн хот руу автобусаар явж, байгалийн үлэг гүрвэлийн музейн цогцолборыг үзэж сонирхоод үүрээр эргээд Хөх хот руу явлаа. Тэр оройдоо Хөх хотын нисэх буудлаас нисч Улаанбаатар хотдоо ирснээр бидний аялал бүрэн дууссан юм. Энэ удаагийн хурал үнэхээр сонирхолтой, сайхан болж, гадны олон эрдэмтэн судлаач нартай танилцаж, цаашдаа харилцаа холбоотой байж, хамтран ажиллахаар тохиролцсон юм.